

Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээ сонин

2023.12.01

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ “ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ”-ЭЭР ШАГНУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Б.Сүнжидмаа, Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Б.Баасансүрэн нар Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр өнөөдөр шагнууллаа.

Шагналыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах гардуулж, баяр хүргэн ажлын өндөр амжилт хүслээ.



Хууль зүйн мэдээ

Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1,
Хууль зүйн үндэсний хүрээлэн.

11-315789

www.nli.gov.mn

Бэлтгэсэн: Э.Цэрэндүгээ

ШҮҮГЧ, ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН НҮБ-ЫН ТУСГАЙ ИЛТГЭГЧ МАРГАРЕТ САТТЕРТУЭЙТЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Хууль зүйн үндэсний Маргарет Саттертуэйт, зүйн боловсролыг дэмжих хүрээлэнгийн захирал НҮБ-ын Хүний эрхийн хөтөлбөр, 1800-1202 подкаст Х.Эрдэм-Ундрах Дээд Комиссарын алба болон эрх зүйн хөтөч бэлтгэх (Dr.jur), Эрдэмтэн (ХЭДКА)-ын хүний эрхийн сургалтын талаар харилцан нарийн бичгийн дарга мэргэжилтэн Мелание мэдээлэл солилцлоо. М.Түвшинжаргал(Ph.D) Сантизо болон Тусгай Тус уулзалтад Эрдэм нар 2023 оны 11 дүгээр илтгэгчийн туслах Катарина шинжилгээний ахлах сарын 08-ны өдөр Шүүгч, Сидов нарыг хүлээн авч ажилтан О.Энххүслэн, Эрдэм өмгөөлөгчдийн хараат бус уулзлаа. шинжилгээний ажилтан байдлын асуудал хариуцсан Уулзалтын үеэр ХЗҮХ-ийн Д.Дэмидханд нар оролцов. Нэгдсэн Үндэстний захирал Х.Эрдэм-Ундрах Байгууллагын Тусгай илтгэгч (Dr.jur) бүх нийтийн эрх



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 35, 17, 4 ДҮГЭЭР СУРГУУЛЬД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн Нийслэлийн ерөнхий боловсролын 35, 17, 4 дүгээр сургуулийн 205 сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Арга зүйч багш Д.Цэцэгдарь хичээл заав.



**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 57, 70, 39 ДҮГЭЭР СУРГУУЛЬД СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Хууль зүйн үндэсний хүрээлэн Нийслэлийн ерөнхий боловсролын 70, 57, 39 дүгээр сургуулийн сурагчдад “Цахим орчин дахь хүүхдийн эрх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хуульч Р.Хатансайхан хичээл зааж, 155 сурагч хамрагдлаа.



**ЭРҮҮГИЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО**



Монголын Өмгөөлөгчдийн Холбоо Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн үеэр Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн танилцуулга, үзэл баримтлалыг өмгөөлөгч Б.Бат-Ерөөлт танилцууллаа.

Хэлэлцүүлэгт оролцсон өмгөөлөгчдөөс хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн талаар гаргасан саналуудыг нэгтгэн холбогдох ажлын хэсэгт хүргүүлэх юм.

БНСУ-ЫН СОЛОНГОСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН (KLRI)-ГЭЭС ЦАХИМ СЕМИНАРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI)-гийн хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчид Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах судлаач, хууль зүйн ухааны доктор Ким Хён Гүний “Солонгос улсын оюуны өмчийн тухай хууль” сэдэвт семинарт хамрагдлаа.



ИРГЭН ТАНД ХУУЛЬ ЗҮЙН
ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЛИЙГ
ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХҮРГЭХ УТАС

1800-1802 ЦАГИЙН ХУВААРЬ
08:30-17:30

ХУУЛЬ ЗӨВЛӨ
УНДСОН ХИРЭЭ

NLI.GOV.MN

ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРЭГ -ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ ЦУВРАЛ № 111-114

ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРЭГ

Хууль зүйн мэдээллийн төв

Би охинойгоо Хөвсгөл аймагт амьдардаг. Миний охин одоо 11 настай хүүхдийн тэтгэлэг өөрчлөгдөж болох уу? Өмнө нь амьжиргааны доод түвшний тал хувьжар хүүхдийн тэтгэлэг авч байсан. Одоо хэд болох вэ?

Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд **11 хүртэлх насны хүүхдэд амьжиргааны доод түвшний 50 хувиар, 11-16 /сүргүүлд суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд хүн амьжиргааны доод түвшний 100 хувиар тогтооно. Таны хүүхэд 11 нас хүрсэн тул хүүхдийн тэтгэлэг 100 хувиар авна. 2023 оны байдлаар Хөвсгөл аймаг дахь хүн амьжиргааны доод түвшин 282,500 төгрөг байна.**

Хууль зүйн мэдээллийн төв
1800-1802 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 111

ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРЭГ

Хууль зүйн мэдээллийн төв

Манай хүүхэд 13 настай 10 жилийн өмнө хүүхдийн тэтгэлэг тогтоолгосон шүүхийн шийдвэр гарсан боловч одоо болтол хүүхдийн тэтгэлгээ аваагүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаж болох уу? Хөөн хэлэлцэх хугацаа гэж байдаг уу?

Хүүхдийн тэтгэлэг тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэртэй тохиолдолд хүүхдийг 16 нас/сурдаг бол 18 нас/ хүртэл хугацаанд хүүхдийн тэтгэлгийг албадан гаргуулахаар хандаж болно. Та хэрэг хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхэд **"Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх шүүгчийн захирамж, гүйцэтгэх хуудасны хамт гаргуулах"** тухай хүсэлтээ гаргах эрхтэй. Хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад өгнө.

Хууль зүйн мэдээллийн төв
1800-1802 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 112

ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРЭГ

Хууль зүйн мэдээллийн төв

Би нэг залуутай хамтран амьдарч байгаад хүүхдтэй болсон юм. Гэтэл нэгөө залуу хүүхдээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Би одоо хүүхдэдээ тэтгэлэг шаардаж болох уу?

Эцэг нь хүүхдээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд хүүхдийн эцгийн оршин суугаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүхэд **"Эцэг тогтоолгож, хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай"** нэхэмжлэл гаргана. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эцэг нь мөн эсэхийг мэргэжлийн шинжилгээний байгууллага тогтооно. Эцэг мөн гэж тогтоогдсон тохиолдолд гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдэдээ тэтгэлэг тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргах хууль зүйн үндэслэлтэй.

Хууль зүйн мэдээллийн төв
1800-1802 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 114

ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРЭГ

Хууль зүйн мэдээллийн төв

Нөхөр бид хоёр 2022 оны 01 дүгээр сард БЗД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр орж гэрлэлтээ цуцлуулсан тэтгэл нөхөр одоо хүртэл хүүхдийн тэтгэлгээ өгөхгүй байна. Ингээд өгөхгүй яваад л байвал би хаана хандаж тэтгэлгийн мөнгөө авах вэ?

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дэх хэсэгт зааснаар тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар заасан байдаг. Иймээс та нөхрөө тэтгэлэг төлөхгүй байгаа талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид хандан хуулийн хариуцлага хүлээлгэх эрхтэй.

Хууль зүйн мэдээллийн төв
1800-1802 дугаар

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

ЦУВРАЛ 113

ИРГЭН ТАНД ХУУЛЬ ЗҮЙН
ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЛИЙГ
ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХҮРГЭХ УТАС

1800-1802

ЦАГИЙН ХУВААРЬ
08:30-17:30



